



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2024.06.03 № 01/498
танай _____-ны № _____-т

Тогтоолын хавсралтад
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаа “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтад заасан “Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-аар Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын зарим албан хаагчдын цалин буурсан, зарим албан тушаал орхигдсон байна.

Иймд Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад хавсралтад зааснаар нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж байна.

Зохих хууль, журмын дагуу шийдвэрлүүлж өгөхийг хүсье.

Холбогдох мэдээллийг хавсаргав.

Хавсралт 6... хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ
ХЭЛТСИЙН ДАРГА




Л.ОЮУНЖАРГАЛ

152240167

d:\2024\тоот\06.03-498.docx

Цаг уур, орчны шинжилгээний газрын
2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн
01/498 дугаар албан бичгийн хавсралт



ТАНИЛЦУУЛГА

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарт өнөөдрийн байдлаар 1893 албан хаагч ажиллаж байна.

Орон нутагт ажиллаж буй ус цаг уур, орчны албан хаагчид нь ээлжийн горимоор үйл ажиллагаа явуулж, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл, учирч болох эрсдэлээс сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахын зэрэгцээ бэлчээрийн болон таримал ургамлын ажиглалт, бороо, цасны хээрийн хэмжилт гэх мэт олон төрлийн ажиглалт, хэмжлийг хөтөлбөрийн дагуу гүйцэтгэдэг.

Дээрх тогтоол гарсантай холбогдуулан Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний салбарын албан хаагчдын гаргаж буй санал, хүсэлтэд үндэслэн цалингийн хэмжээнд судалгаа хийж, ЗГ-ийн 2023 оны 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралт албан хаагчдын цалингийн доод хэмжээг ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтын цалингийн доод хэмжээтэй харьцуулж үзэхэд манай салбарын 1300 гаруй албан хаагчдын цалин 800-136000 хүртэл төгрөгөөр нэмэгдсэн бол ТҮМ-9 зэрэглэлд хамрагдаж буй аймаг, нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нар ТҮМ-7 зэрэглэлд хамрагдаж буй аймаг, нийслэлийн төвийн дарга нар болон харьяа байгууллагын хэлтсийн дарга нарын цалин 200-72000 төгрөгөөр буурсан дүн гарсан.

Тус газрын харьяа байгууллагуудын нэгжийн дарга нарын цалин 72,000 төгрөгөөр буурсан нь Төрийн албаны тухай хуулийн 9.2, 62.1.4 дүгээр заалтууд зөрчигдөж байна. Иймд эдгээр төрийн албан хаагчдын зэрэглэлийг ахиулан ТҮМ-8 зэрэглэлд хамруулах саналтай байна.

ТҮМ-7-гоос ТҮМ-3 дугаар зэрэглэлд Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн гаргасан ажлын байр, нэршлийн журмын дагуу ахлах мэргэжилтэн, технологич инженер, ахлах инженер, радарын ахлах инженер, ахлах нягтлан бодогч, лабораторийн техникч, ахлах техникч зэрэг албан тушаал орхигдсон байна. Энэ нөхцөл байдлын улмаас салбарын хэмжээнд олгогддог Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 дугаартай тушаалаар батлагдсан төв, орон нутгийн мэргэшсэн албан хаагчдад олгогдох мэргэжлийн зэрэг олгох журам, Засгийн газрын холбогдох тогтоолуудын уялдаа холбоог хангах, албан хаагчдын нийгмийн баталгаа, орлого буурах, Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний салбарын албан хаагчдын эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэхээр нөхцөл үүсэж болзошгүй тул дээрх тогтоолын хавсралтыг өөрчлүүлэх саналтай байна.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

Засгийн газрын 2024 оны 02 дугаар
сарын 28-ны өдрийн 84 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

Засгийн газрын 2023 оны 06 дугаар
сарын 21-ний өдрийн 240 дүгээр
тогтоолын 7 дугаар хавсралт

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН БУСАД БАЙГУУЛЛАГЫН
АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ, ТҮҮНД ХАМААРАХ АЛБАН
ТУШААЛЫН ЖАГСААЛТ-д нэмэлт өөрчлөлт оруулах санал**

№	Зэрэглэл	Албан тушаал		Тайлбар үндэслэл
		Удирдах	Гүйцэтгэх	
1	2	3	4	5
1.	ТҮМ-10			
2.	ТҮМ-9			
3.	ТҮМ-8	1.Үндэсний төв архивын нэгжийн дарга, салбар архивын дарга 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн чанар, техникийн менежер, нийслэлийн лабораторийн дарга 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн ерөнхий эмч 4.Нислэгийн цаг уурын төвийн аюулгүй байдал, чанарын менежер 5.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн нэгжийн дарга 6.Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн нэгжийн дарга 7.Нислэгийн цаг уурын төвийн нэгжийн дарга 8.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн нэгжийн дарга		Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал"-ын цалингийн доод хэмжээний ТҮ-10 зэрэглэлээр цалинждаг байсан нэгжийн дарга нар Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолын "Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаал"-ын цалингийн доод хэмжээний ТҮМ-7 зэрэглэлд хамагдснаар цалин хөлс нь 72200 төгрөгөөр буурсан байна. ИнгэснээрТөрийн албаны тухай хуулийн 9.2, 62.1.4 дүээр заалтууд зөрчигдөж байна. Иймд ТҮМ-8 зэрэглэлд шилжүүлэх саналтай байна.

1	2	3	4	5
4.	ТҮМ-7	1.Төрийн архив, салбар архивын нэгжийн дарга 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн эрхлэгч, нэгжийн дарга 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн эрхлэгч, нэгжийн дарга	1.Цаг уур, орчны шинжилгээний газрын ерөнхий инженер, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер 2.Нислэгийн цаг уурын төвийн аюулгүй байдал, чанарын хяналтын ахлах мэргэжилтэн 3.Ерөнхий нягтлан бодогч 4.Нийслэлийн лабораторийн чанарын менежер, техникийн менежер 5. Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн урьдчилан мэдээлэхийн технологич инженер	ТҮМ-7-гоос ТҮМ-3 дугаар зэрэглэлд Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн гаргасан ажлын байр, нэршлийн журмын дагуу ахлах мэргэжилтэн, технологич инженер, ахлах инженер, радарын ахлах инженер, ахлах нягтлан бодогч, лабораторийн техникч, ахлах техникч зэрэг албан тушаал орхигдсон байна. Энэ нөхцөл байдлын улмаас салбарын хэмжээнд олгогддог Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 дугаартай тушаалаар батлагдсан төв, орон нутгийн мэргэшсэн албан хаагчдад олгогдох мэргэжлийн зэрэг олгох журам, Засгийн газрын холбогдох тогтоолуудын уялдаа холбоог хангах, албан хаагчдын нийгмийн баталгаа, орлого буурах, Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний салбарын албан хаагчдын эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэхээр нөхцөл үүсэж байна. Тайлбар: bold-оор бичсэн нь шинээр оруулах, дундуур зурсан нь устгах
5	ТҮМ-6		1.Төрийн архивын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, ахлах зааварлагч-арга зүйч, ахлах архивч, ахлах сэлбэн засагч, ахлах архивч-операторч, хадгалалт хамгаалалтын технологич, мэдээллийн технологийн ажилтан 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ахлах шинжээч 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн ахлах шинжээч, судлагч 4. Цаг уур, орчны шинжилгээний газрын урьдчилан мэдээлэхийн инженер, ахлах мэргэжилтэн 5.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн байгаль-орчны ахлах шинжээч, ахлах мэргэжилтэн, технологич инженер, 6.Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн ерөнхий	

1	2	3	4	5
			инженер, ахлах мэргэжилтэн, ахлах инженер, технологич инженер 7.Нислэгийн цаг уурын төвийн ерөнхий инженер, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер, ахлах мэргэжилтэн 10.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн урьдчилан мэдээлэхийн технологич инженер, лабораторийн эрхлэгч, салбар хариуцсан технологич инженер, ахлах мэргэжилтэн 11.Ахлах нягтлан бодогч	
6.	ТУМ-5		1.Төрийн архивын эрдэм шинжилгээний ажилтан, зааварлагч-арга зүйч, архивч, кино дүрс бичлэгийн инженер, сэлбэн засагч, зохион байгуулагч 2.Төрөлжсөн болон тусгай архивын ахлах зааварлагч-арга зүйч, ахлах архивч, ахлах архивч-операторч, хадгалалт хамгаалалтын технологич 3.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн шинжээч 4.Сорьц тогтоох лабораторийн химич-шинжээч, хэмжил зүйн техникч, 5.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дээж хүлээн авагч эмч, судлагч 6.Цаг уур, орчны шинжилгээний газрын инженер, мэргэжилтэн 7.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн байгаль—орчны шинжээч, мэргэжилтэн, инженер	

1	2	3	4	5
			8.Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн ахлах инженер, мэргэжилтэн 9.Нислэгийн цаг уурын төвийн инженер, мэргэжилтэн, радарын инженер 10.Нийслэлийн лабораторийн шинжээч, дээж хүлээн авагч 11.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн инженер, ахлах мэргэжилтэн, байгаль—орчны ахлах шинжээч 12.нягтлан бодогч	
7.	ТУМ-4		1.Төрийн архивын микрофильмийн техникч, микрофиш, фильмийн хальс боловсруулагч, сан хөмрөгч, уншлагын танхимын эрхлэгч, архивч-операторч, архивч-эх бэлтгэгч 2.Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч 3.Төрөлжсөн болон тусгай архивын зааварлагч-арга зүйч, архивч, сэлбэн засагч, архивч-операторч 4.Сорьц тогтоох лабораторийн сорьц дарагч, үнэт металл хайлагч 5.Аймаг, орон нутгийн лабораторийн шинжээч, дээж авагч, их эмч, судлагч, 6.Аймаг, хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн мэргэжилтэн, байгаль—орчны шинжээч, газгенераторч, ахлах техникч, цаг уурын ажиглагч	

1	2	3	4	5
			7.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч 8.Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн ахлах техникч 9. Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн техникч	
8.	ТУМ-3		1.Төрийн архивын дэвтэрлэгч, хэвлэгч, химич-лаборант, галын болон хамгаалалтын системийн техникч, баримт ариутгагч 2.Яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-аас бусад байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч, архивч 3.Лабораторийн лаборант, техникч, устөрөгчийн баллон цэнэглэгч, ус цаг уурын ажиглагч-техникч	
9.	ТУМ-2		1.Лабораторийн автоклавчин	
10.	ТУМ-1		1.Лабораторийн шил угаагч, ариутгагч	

----ooOoo----